



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг хангасан эрүүл мэндийн байгууллагуудыг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг "Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр"-т тусган батлуулж, хэрэгжүүлэхийг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/ -д тус тус үүрэг болгосугай.


САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080421

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 24 сарын 06 ны өдрийн
4 дугаар тушаалын хавсралт
133



**Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур
үзүүлэлтийг хангасан эрүүл мэндийн байгууллагууд**

| № | Эрүүл мэндийн байгууллагын нэрс | Батламжийн дугаар | Магадлан итгэмжлэгдсэн хугацаа | Магадлан итгэмжлэл эхлэх огноо | Магадлан итгэмжлэл дуусах огноо | Шалгуур үзүүлэлтийг хангасан хувь |
|----|--|-------------------|--------------------------------|--------------------------------|---------------------------------|-----------------------------------|
| 1. | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | 36/2017 | 5 жил | 2017-03-13 | 2022-03-13 | 97,0 |
| 2. | Улсын гуравдугаар төв эмнэлэг | 37/2017 | 5 жил | 2017-03-13 | 2022-03-13 | 96,3 |
| 3. | Арьсны өвчин судлалын үндэсний төв | 38/2017 | 4 жил | 2017-01-14 | 2021-01-14 | 91,0 |
| 4. | Геронтологийн үндэсний төв | 39/2017 | 3 жил | 2017-03-13 | 2020-03-13 | 90,0 |
| 5. | Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв | 40/2017 | 3 жил | 2017-03-13 | 2020-03-13 | 91,3 |
| 6. | Баянзүрх дүүргийн "Цэн-Оюу" өрхийн эрүүл мэндийн төв | 41/2017 | 2 жил | 2017-03-24 | 2019-03-24 | 87,2 |
| 7. | Сүхбаатар дүүргийн "Увидаст-Од" өрхийн эрүүл мэндийн төв | 42/2017 | 2 жил | 2017-03-24 | 2019-03-24 | 87,6 |